



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/373

Есөнбулаг сум

Малын шилжилт хөдөлгөөнийг
хориглох хугацааг сунгах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 6.3, 6.4, 15 дугаар зүйлийн 15.5.1, 15.5.2 дахь заалт, Монгол улсын засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 01/952 дугаартай албан тоот, аймгийн Онцгой комиссын 7 хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний нөхцөл байдлаас шалтгаалан аймаг, нийслэл, сум хоорондын малын шилжилт хөдөлгөөнийг хориглосон хугацааг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2026 оны 08 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл сунгасугай.

2.Малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг эрчимжүүлэн холбогдох хууль тогтоомж, энэхүү захирамжийг зөрчсөн, худал мэдээлэл тарааж иргэдийг төөрөгдүүлсэн иргэн, хуулийн этгээдийг хуулийн хүрээнд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахыг аймгийн Цагдаагийн газар (Д.Бүрэнбаатар), Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах), Онцгой байдлын газар (Ц.Лувсанжамц) нарт, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Хүнсний зориулалтаар хэрэглэх, худалдан борлуулах малын маханд мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээг олгох, нэвтрүүлэхийг Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах), сумдын Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нар, хяналтын цэгүүдэд зөвшөөрсүгэй.

4.Аймаг, сумын баяр наадмаас бусад (Хурдан морины бооцоот уралдаан, овоо тахилгын баяр, ургийн баяр зэрэг) арга хэмжээнд хурдан морины уралдаан зохион байгуулахгүй байхыг сумын Засаг дарга нарт, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Д.Бүрэнбаатар)-т даалгасугай.

5.Малын гоц халдварт шүлхий өвчин бүртгэгдсэн аймгаас ирэх замуудад хориглосон хугацаанд хяналтын пост нэмж ажиллуулахыг Тонхил, Дарив, Хөхморьт сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Алтангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ

